



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А-211

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, "Барилгын тухай" хуулийн 37.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 2.8, 3.1.4 дэх заалт, Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А-1/779 тоот албан бичгээр өгсөн зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт"-ын XVII.1.14 "Ахуйн үйлчилгээний барилга /Хөвсгөл, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад барилгын ажлыг 925,750,119.0 /Есөн зуун хорин таван сая долоон зуун тавин мянга нэг зуун арван ес/ төгрөгөөр гүйцэтгэхээр "Голден прогресс" ХХК-ийн ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн, "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа тендер хүчинтэй байх хугацаанд багтаан шалгарсан оролцогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга /Я.Эрдэнэсайхан/-д даалгасугай

3. "Ахуйн үйлчилгээний төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, захиалагчийн болон зохиогчийн хяналтын гэрээ байгуулах, хяналт тавих, гэрээ дүгнэх, барилгын ажлыг улсын комисс хүлээн авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах төслийн менежерээр Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Я.Эрхэмбаяр/-ыг томилсугай.

ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000846